



МОНГОЛ УЛС
ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 11531

Мандалговь

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малын гоц халдварт "Шүлхий" өвчин Баянжаргалан сумын 2 дугаар багийн нутаг "Мааньт-Марзан" гэх газар гарч, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн шинжилгээгээр оношлогдсон тул уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор тус сумыг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсүгэй.

Хоёр. Мал, амьтны гоц халдварт "Шүлхий" өвчин гарсантай холбогдуулан энэ өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянжаргалан сумтай хил залгаа Говь-Угтаал, Гурван сайхан, Цагаандэлгэр, Өндөршил сумдад хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг дээрх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. "Шүлхий" өвчинтэй тэмцэх журмыг мөрдүүлэх, гадагш тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулан пост гаргах, малын шилжилт хөдөлгөөн, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглох, урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авч хамтарч ажиллахыг Онцгой байдлын газар /дарга, хурандаа Я.Алтанхундага/, Цагдаагийн газар /дарга, хурандаа М.Ганбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /дарга, Ш.Төрбат/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /дарга Б.Мөнхжаргал/, Баянжаргалан сумын Засаг дарга /Г.Туяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн биелэлтийг ханггуулж, нэгдсэн удирдлагаар ханган, үр дүн ажлын явцыг тухай бүр танилцуулж байхыг Онцгой байдлын газар /дарга, хурандаа Я.Алтанхундага/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

0271429